

Аудитын код: САГ-2018/81/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Я. Самбууням
Утас: 261885 Цахим хаяг: sambuunyamyam@audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 261740 Цахим хаяг: nyamdavaan@audit.gov.mn

Улаанбаатар хот



Агуулга

1	АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ	0
2	Аудитын тайлан.....	2
2.1	Оршил.....	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	2
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	3
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	3
2.5	Дотоод хяналт	4
2.6	Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	4
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	5
2.9.1	Авлага, өглөгийн талаар	5
2.9.2	Орлогын талаар	5
2.9.3	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	6
2.9.4	Шилэн дансны талаар.....	6
2.9.5	Улсын тэмдэгтийн хураамжийн талаар.....	6
2.9.6	Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар	6
2.9.7	Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаар.....	7
2.9.8	Цалин хөлсний талаар.....	7
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	8
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	8
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	8
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3	Менежментийн захидал	9
3.1	Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар	10
3.2	Шилэн дансны талаар	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	14
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	15
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	16

1 АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.15 № 06/737
танай -ны № -т

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ
ХОРООНЫ ДАРГА А.ТЛЕЙХАН ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлангматериаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10.20\B..._Khanagiyevan_Bichig20180315SACKS.docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Эрчим хүчний зохицуулах хороо нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

УХАА0122

\\10.10.10.20\Bichig_Kherag\Yawsan_Bichig\2018\0315SAG58.Docx

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгад хийсэн санхүүгийн аудитын тайланг Эрчим хүчний зохицуулах хорооны дарга А.Тлейхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрчим хүчний зохицуулах хороо санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон НББОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 12-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, Эрчим хүчний зохицуулах хороонд хүргүүлэхээр төлөвлөн, “Мишээл-Од Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг нар удирдан зохион байгуулж ахлах аудитор САГ-2018/81/-СТА-ТӨҮГ

О.Цэндхүү, Б.Цогзолмаа, аудиторын туслах Т.Алтанчимэг, Б.Энхболор, М.Батмагнай нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар хороо нь 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 8/278 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Эрчим хүчний зохицуулах хороо санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/, Сангийн сайдын 2012 оны 77 дугаар тушаалаар баталсан Аж ахуйн нэгж байгууллагад мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол улсын эрчим хүчний тухай хуулийн 5.1.2, 8.1, Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 8.1-д заасныг үндэслэн Монгол улсын засгийн газрын 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн 132 дугаар тогтоолоор Эрчим хүчний зохицуулах хорооны дүрмийг баталсан байна.

Эрчим хүчний зохицуулах хорооны бүрэн эрх:


- Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйл, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуулийн 5.6 дахь хэсэг Эрчим хүч хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйл заалтууд
- Эрчим хүчний салбарын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар санал боловсруулах
- Хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд холбогдох дүрэм, журам, заавар, аргачлал, баталж мөрдүүлэх
- Эрчим хүчний салбарт тусгай зөвшөөрөлтэй болон магадлан итгэмжлэлтэй үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, болон үүрэг хүлээсэн хэрэглэгч, холбогдох бусад этгээдээс тайлан, мэдээ, мэдээлэл, тодорхойлолт гаргуулан авах
- Аймаг нийслэлийн эрчим хүчний зохицуулах зөвлөлийн үйл ажиллагааны зардлын төсөв, төсвийн гүйцэтгэлийг хянах
- Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, үйл ажиллагаанд нь хяналт шалгалт хийх

Эрчим хүчний зохицуулах хорооны үндсэн зорилго нь Эрчим хүчний хангамжийн найдвартай ажиллагаа, салбарын санхүү эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үр ашгийг дээшлүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих, эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх болон хангагч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалахад чиглэсэн зохицуулалттай, өрсөлдөөнт зах зээлийн тогтолцоог бүрдүүлнэ.

Эрчим хүчний зохицуулах хорооны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн зорилго, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000–1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, НББОУС, Санхүүгийн



тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар тус хорооны 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 8 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 32 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Эрчим хүчний зохицуулах хорооны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Эрчим хүчний зохицуулах хороо нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Винница” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Эрчим хүчний зохицуулах хорооны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

2.6 Төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга


Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 37 дугаар тогтоолоор тус хорооны 2017 оны зардал, хөрөнгө орлуулалтын зорилтот түвшинг баталгаажуулжээ.

Тайлант онд 5,111.9 сая төгрөгийн орлого олж, 3,893.6 сая төгрөгийг зарцуулж, 1,218.3 сая төгрөгийн ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 5,301.6 сая төгрөгийн орлого олж 3,912.3 сая төгрөгийг зардалд зарцуулж, 1,389.3 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, 2015 оноос тус хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд шилэн дансанд холбогдох мэдээллүүдийг тус байгууллагын мэдээлэл технологийн ажилтан байршуулж байна.

<http://shilendans.gov.mn> цахим хуудсанд бүртгэгдээгүй, байгууллагын цахим хуудсанд шилэн дансыг байршуулж, байгууллагын 2016, 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайланг тайлагнасан байна. Шилэн дансны хуульд заасан бусад мэдээллийг байршуулаагүй байна.



2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 8 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 32 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлага, өглөгийн талаар

Тус хорооны 2017 оны авлага, өглөгийн бүртгэлд 9.5 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

1. Хувь хүнээс авах 0.5 сая төгрөгийн авлагыг өөрийн байгууллагаас авах авлагаар ангилан буруу бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т “ерөнхий нягтлан бодогч ...”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, ... ажлыг зохион байгуулах, удирдах”, 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон ... үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах”, гэсэн заалт;

2. Тайлант онд 6 ажилтанд 90.0 сая төгрөгийн орон сууцны хөнгөлөлтийг олгохдоо 9.0 сая төгрөгийн Хувь хүний орлогын албан татварыг суутган аваагүй, татварын тайланд тусгаагүй.


Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан татвар төлөгчийн цалин,”, 11.1.2-т “ажил олгогчоос ажилтан, ... олгосон тэтгэмж болон түүнтэй адилтгах орлого”, гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бусад авлага 0.5 сая төгрөгийг харилцагч тус бүрээр, 9.0 сая төгрөгийн татварын өглөгийг ажилтан албан хаагчидаас авах авлагаар санхүүгийн тайланд тусгуулж аудитын явцад залруулсан;

2.9.2 Орлогын талаар

Тайлант онд 148.5 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийг орлогын тайланд тусгахдаа Бусад ашиг, алдагдал дансанд бүртгэсэн.

Энэ нь Сангийн сайдын 2014 оны 249 тоот тушаалаар батлагдсан Аж Ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн зааврын 2.2.1 Үндсэн хөрөнгө хэсгийн 3-т зааснаар “Буцалтгүй тусламж, бэлэг хандиваар олж бэлтгэх. Аж ахуйн нэгж нь үнэ төлбөргүйгээр буюу буцалтгүй тусламж, бэлэг, хандиваар үндсэн хөрөнгийг олж бэлтгэсэн бол хүлээн авсан хөрөнгийг бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлант үеийн орлого/хойшлогдсон орлогоор хүлээн зөвшөөрнө” гэсэн заалттай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Үнэ төлбөргүй хүлээн авсан 148.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг Бусад орлого дансанд бүртгүүлж аудитын явцад залруулсан;

2.9.3 Улсын бүртгэлийн гэрчилгээний талаар

Дүрмийн сангийн хэмжээ санхүүгийн тайланд тусгагдсанаар 104.5 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 120.0 сая төгрөг буюу 15.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 4.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгө; гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах, улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах талаар зөвлөмж өгөх;

2.9.4 Шилэн дансны талаар

Тус хороо нь <http://shilendans.gov.mn> цахим хуудсанд бүртгэгдээгүй, хорооны цахим хуудсанд 2016, 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайланг тайлагнасан. Эдгээрээс бусад мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд бүртгүүлэх, шилэн дансны тухай хуулийг мөрдөж ажиллах талаар зөвлөмж өгөх;

2.9.5 Улсын тэмдэгтийн хураамжийн талаар

Улсын тэмдэгтийн хураамжийн тайлангаар тайлант оны эхэнд 59.1 сая төгрөг, тайлант оны эцэст 281.2 сая төгрөгийн өрийн үлдэгдэлтэй тайлан гаргаж татварын байгууллагад тушааж баталгаажуулсан боловч тус өр төлбөр нь санхүүгийн тайланд бүртгэгдээгүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3-д “бүх өр төлбөр” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 221.7 сая төгрөгийн байгууллагаас авах авлага, татварын байгууллагад өгөх өр төлбөрийг санхүүгийн тайланд залруулж, эзэн холбогдогч нь тодорхойгүй 59.6 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн төлбөрийг эзэн холбогдогчийг тогтоож, баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх;

2.9.6 Нэмэгдсэн өртгийн албан татварын талаар

Хороо нь борлуулалтын орлогоос Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй, тус татварын төрлөөр татвар төлөгчөөр бүртгүүлээгүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-д “Үйл ажиллагааны борлуулалтын орлогын хэмжээ нь 50 сая ба ...”, 5.2.1-д “Монгол Улсын нутаг дэвсгэрт ...”, 7.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол ...”, 7.1.1-д “Монгол



Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ”; гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчөөр бүртгүүлж, татвар ногдуулах албан шаардлага хүргүүлэх;

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх;

2.9.7 Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлсний талаар

ҮАГ-аас 2016 онд эрчим хүчний тусгай зөвшөөрөл олголтын байдалд хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар “Эрчим хүчний зохицуулалтын үйлчилгээний хөлс тооцох аргачлал”-ыг шинэчлэн батлах тухай зөвлөмж өгсөн байхад одоог хүртэл биелэгдээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, ...” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх албан шаардлага хүргүүлэх;

2.9.8 Цалин хөлсний талаар

Ээлжийн амралтын олговрыг тооцохдоо хоол унааны хөнгөлөлтийг дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулан тооцсон, ажлаас халагдсан ажилтнуудын амралтыг тооцоог буруу тооцсоноос 19 ажилтанд 2.9 сая төгрөгийн амралтын олговрыг илүү олгосон байна.

Энэ нь Эрүүл мэнд, нийгмийн хамгаалалын сайдын 2000 оны 166 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Ээлжийн амралт олгох заавар”-ын 15-д “Ажилтан ажлаас халагдах үед ажил олгогч нь түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийнэ. Ээлжийн амралтын тооцоог дор зааснаар хийнэ. ...”

Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн сайдын 2005 оны 5 дугаар сарын 05-ны өдрийн 55 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 4-д “Ажилтанд олгож байгаа бүх төрлийн ... унаа, түлш, байр, хоолны үнийн хөнгөлөлт/-ийг ажилтны цалин хөлсний бүрэлдэхүүнд оруулахгүй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.


Шийдвэрлэсэн нь:Төлбөрийг барагдуулах акт тогтоох;

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Анхаарал татахуйц бусад чухал асуудал гараагүй болно.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл,



тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан учир дараагийн аудитаар авч үзэх ноцтой асуудлууд байхгүй гэж бид үзсэн болно.

Аудитын явцад илэрсэн залруулагдсан болон залруулагдах боломжгүй учир зөвлөмж, акт, албан шаардлага өгсөн асуудлуудыг давтан гаргаж байгаа эсэх мөн биелэлтийн талаар 2018 оны завсрын аудитаар дахин хянах болно.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын явцад материаллаг 235.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 158.0 сая төгрөгийн 3 зөрчил залруулагдаж, 59.1 сая төгрөгийн 2 албан шаардлага, 2.9 сая төгрөгийн 1 акт, 15.5 сая төгрөгийн 2 зөвлөмж, Үүнээс улсын бүртгэлийн гэрчилгээнд дүрмийн сангийн хэмжээ 15.5 сая төгрөгөөр зөрүүтэй тусгагдсан зөрчлийг шинж чанарын хувьд материаллаг бус зөрчил гэж үзлээ.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрчим хүчний зохицуулах хорооны 2016 оны санхүүгийн тайланд “Ас- Арвай аудит” ХХК аудит хийж 1 зөвлөмж өгснийг биелүүлж ажилласан байна. 2017 онд ҮАГ-аас гүйцэтгэлийн аудит хийгдэж 213.3 сая төгрөгийн акт тогтоосныг 48.7 сая төгрөг буюу 22.8 хувиар, 306.5 сая төгрөгийн албан шаардлагын 274.8 сая төгрөг буюу 90.0 хувийг биелүүлсэн байна.

Зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн ажлын тайланг Эрчим хүчний зохицуулах хорооны даргын 2018 оны 01 дугаар сарын 10-ны өдрийн 1/32 тоот албан тоотоор ирүүлсэн болно.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын батлагдсан төлөвлөгөөг сонгов.

Зардал өмнөх оны гүйцэтгэлээс 518.4 сая төгрөгөөр өссөн тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын суурийг тайлант оны зардлын гүйцэтгэл 3,912.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 39.2 сая төгрөгөөр тогтоов.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулгыг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрчим хүчний зохицуулах хорооны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, НББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж дүгнэн “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.



3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Эрчим хүчний зохицуулах хорооны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

3.1 Улсын бүртгэлийн гэрчилгээний ТАЛААР	Тэргүүлэх ач холбогдол №1
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Дүрмийн сангийн хэмжээ санхүүгийн тайланд тусгагдсанаар 104.5 сая төгрөг байхад улсын бүртгэлийн гэрчилгээнд 120.0 сая төгрөг буюу 15.5 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн.

Энэ нь Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д “Хуулийн этгээд доор дурдсан мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлнэ”, 4.1.3.хувь нийлүүлсэн хөрөнгө; гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн үнэн зөв, эрх үүрэг батламжийн мэдэгдлүүд зөрчигдөх;

ҮАГ-ын зөвлөмж

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон Хууль зүйн сайдын 2015 оны А/39 дүгээр тушаалын хавсралт “хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтлөх журам”-ыг мөрдөж ажиллах, Улсын бүртгэлийн гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулах;

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.



3.2 Шилэн дансны талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
--------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Тус хороо нь <http://shilendans.gov.mn> цахим хуудсанд бүртгэгдээгүй, хорооны цахим хуудсанд 2016, 2017 оны төлөвлөгөө, гүйцэтгэл, аудитлагдсан санхүүгийн тайланг тайлагнасан. Эдгээрээс бусад мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ ...” гэсэн заалт болон бусад заалтуудыг мөрдөж ажиллах,

Зөвлөмжийн биелэлтийг 2018 оны 7 дугаар сарын 02-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

Эрсдэлүүд

Шилэн дансны тухай хуулийн заалт зөрчигдөж, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдэл зөрчигдөх;

Үйлчлүүлэгчийн хариу

Зөрчлийг цаашид давтан гаргахгүй, аудитын зөвлөмжийг биелүүлж ажиллана.

АУДИТЫН ТАЙЛАН, МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

АУДИТЫН БАГИЙН АХЛАГЧ

Т.ОДОНЧИМЭГ

БЭЛТГЭСЭН:

“МИШЭЭЛ-ОД АУДИТ” ХХК-ИЙН АУДИТОР

Э.ЭНХЦЭЦЭГ

Огноо: 2018.03.13



4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН**4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	166,659,577.20	1,682,791,498.72
Дансны авлага	937,564,737.51	413,004,378.23
Татвар, НДШ-ийн авлага	176,460.00	245,651,759.86
Бусад авлага	206,036.49	9,547,877.60
Бусад санхүүгийн хөрөнгө		
Бараа материал	63,465,674.62	10,895,904.15
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	31.46	26,940,963.00
Бусад эргэлтийн хөрөнгө		
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,168,072,517.28	2,388,832,381.56
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	1,562,305,861.41	1,798,737,161.81
Биет бус хөрөнгө		3,894,000.00
Биологийн хөрөнгө		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө		
Хойшлогдсон татварын хөрөнгө		
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
Бусад эргэлтийн бус хөрөнгө		
Хуримтлагдсан элэгдэл		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,562,305,861.41	1,802,631,161.81
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,730,378,378.69	4,191,463,543.37
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
Дансны өглөг	11,378,828.00	1,969,514.00
Цалингийн өглөг		
Татварын өр	53,249,977.87	230,670,000.00
НДШ - ийн өглөг		
Богино хугацаат зээл		4,266.12
Хүүний өглөг		
Ногдол ашгийн өглөг		
Урьдчилж орсон орлого	762,333,146.30	667,085,512.25
Нөөц /өр төлбөр/		
Бусад богино хугацаат өр төлбөр	879,806.98	
Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр		
Богино хугацаат өр төлбөрийн дүн	827,841,759.15	899,729,292.37
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат зээл		

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Нөөц /өр төлбөр/		
Хойшлогдсон татварын өр		
Бусад урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн		
Өр төлбөрийн нийт дүн	827,841,759.15	899,729,292.37
Эздийн өмч		
Өмч: - төрийн	104,537,450.95	104,537,450.95
- хувийн		
- хувьцаат		
Халаасны хувьцаа		
Нэмж төлөгдсөн капитал		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	364,857,785.30	364,857,785.30
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
Эздийн өмчийн бусад хэсэг	66,075,249.21	66,075,249.21
Хуримтлагдсан ашиг	1,367,066,134.08	2,756,263,765.54
Тайлангийн үеийн ашиг	155,338,210.91	1,389,344,985.94
Өмнөх үеийн ашиг	1,211,727,923.17	1,366,918,779.60
Эздийн өмчийн дүн	1,902,536,619.54	3,291,734,251.00
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,730,378,378.69	4,191,463,543.37

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Борлуулалтын орлого (цэвэр)	3,500,111,663.00	5,111,946,875.50
Борлуулалтын өртөг	0.00	0.00
Нийт ашиг(алдагдал)	3,500,111,663.00	5,111,946,875.50
Түрээсийн орлого		
Хүүний орлого		30,235,794.34
Ногдол ашгийн орлого		
Эрхийн шимтгэлийн орлого		
Бусад орлого		159,151,359.81
Борлуулалт, маркетингийн зардал		
Ерөнхий ба удирдлагын зардал	3,318,958,970.44	3,720,052,551.63
Санхүүгийн зардал		
Бусад зардал		
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	622,582.74	90,382.79
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
Бусад ашиг (алдагдал)	48,507,915.32	-6,923,092.16
Олз гарзын дүн		
Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	230,283,190.62	1,574,448,768.65
Орлогын татварын зардал	63,826,410.25	185,103,782.71
Татварын дараах ашиг (алдагдал)	166,456,780.37	1,389,344,985.94
Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)		
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	166,456,780.37	1,389,344,985.94
Бусад дэлгэрэнгүй орлого		
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
Бусад олз (гарз)		
Орлогын нийт дүн	166,456,780.37	1,389,344,985.94
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Өмчийн дүн /төгрөгөөр/
2016 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		61,091,431.21	1,200,609,353.71	1,731,096,021.17
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							-
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		61,091,431.21	1,200,609,353.71	1,731,096,021.17
Тайлант үеийн цэвэр ашиг						166,456,780.37	166,456,780.37
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт					4,983,818.00		4,983,818.00
Зарласан ногдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2017 оны 01 сарын 01-ний үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	1,367,066,134.08	1,902,536,619.54
НБББ-ын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						(147,354.48)	(147,354.48)
Залруулсан үлдэгдэл	104,537,450.95		364,857,785.30		66,075,249.21	1,366,918,779.60	1,902,389,265.06
Тайлант үеийн цэвэр ашиг						1,389,344,985.94	1,389,344,985.94
Бусад дэлгэрэнгүй орлого							-
Өмчид гарсан өөрчлөлт							-
Зарласан ногдол ашиг							-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							-
2017 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	104,537,450.95	-	364,857,785.30	-	66,075,249.21	2,756,263,765.54	3,291,734,251.00

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА


**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	3,141,184,955.50	5,747,741,255.45
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3,095,269,031.00	5,687,691,458.08
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		26,471,468.36
Буцаан авсан албан татвар		
Татаас, санхүүжилтийн орлого		
Бусад мөнгөн орлого	45,915,924.50	33,578,329.01
Мөнгөн зарлагын дүн (-)	3,341,726,844.98	4,021,156,656.05
Ажиллагчдад төлсөн	1,881,439,709.27	2,458,289,240.62
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	382,670,731.59	494,455,893.99
Бараа материал худалдан авахад төлсөн	14,068,330.00	73,450,291.53
Ашиглалтын зардалд төлсөн	35,677,054.70	23,732,184.36
Түлш шатахуун, тээврийн хөлс,сэлбэг хэрэгсэлд төлсөн	44,192,867.04	50,525,455.89
Хүүний төлбөрт төлсөн		
Татварын байгууллагад төлсөн	206,184,796.00	667,337,888.62
Даатгалын төлбөрт төлсөн	15,232.00	4,071,342.00
Бусад мөнгөн зарлага	777,478,124.38	249,294,359.04
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-200,541,889.48	1,726,584,599.40
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
Мөнгөн орлогын дүн (+)	11,053,140.32	30,235,794.34
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		
Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт		
Хүлээн авсан хүүний орлого	11,053,140.32	30,235,794.34
Хүлээн авсан ногдол ашиг		
Бусад		
Мөнгөн зарлагын дүн (-)	110,554,910.00	240,192,200.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	105,765,010.00	240,192,200.00
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	4,789,900.00	
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
Бусад		
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-99,501,769.68	-209,956,405.68



Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
Мөнгөн орлогын дүн (+)	622,582.74	0.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
Төрөл бүрийн хандив		
Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг		
Бусад	622,582.74	
Мөнгөн зарлагын дүн (-)	622,582.74	496,272.22
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
Төлсөн ногдол ашиг		
Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал		
Бусад		496,272.22
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	622,582.74	-496,272.22
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-299,421,076.42	1,516,131,921.52
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	466,080,653.62	166,659,577.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	166,659,577.20	1,682,791,498.72

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**